



УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Б.БАТГЭРЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/354
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Улаанбаатар хот дахь гаалийн газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хот дахь гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б. Батгэрэл

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122
\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2017\0224\SAG31.docx



УБ ХОТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР

2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахь хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Ахлах аудитор: Н.Нямдаваа
Утас: 261863

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол Улс
Цахим хуудас: www.audit.mn
Ворлдвайд файнэнс аудит ХХК
Захирал: Ч.Байгаль
Утас: 99091342
Ахлах аудитор: З.Сумьяа
Утас: 99087154

Аудитын тайлан

Хуудас

Агуулга 2-8

Аудитын гэрчилгээ 9

Менежментийн захидал 10-13

Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 14-17

Төсвийн гүйцэтгэлийн тайлан 18

Хавсралт: “УБ хот дахь Гаалийн газар”-ийн
2016 оны санхүүгийн тайлан .

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудитын хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдлын түвшин
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдлүүд , түүний үр дагавар
10. Гол онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дах заалтыг үндэслэн төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “УБ хот дахь Гаалийн газар”-ийн 2016 оны 12 дугаар сарны 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“УБ хот дахь Гаалийн газар”-ийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“УБ хот дахь Гаалийн газар”-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 27–ноос 2017 оны 2 дугаар сарын 17-ны хооронд хийхээр төлөвлөн “Ворлдвайд фاینэнс аудит” ХХК аудитор Ч.Байгаль хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“УБ хот дахь Гаалийн газар”-ийн 2016 оны санхүүгийн тайлангаа 2017 оны 1 дүгээр сарын 25-нд ирүүлсэн байна.

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2016 оны дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд 2017 оны 01 дүгээр сарын 27-аас 2017 оны 02 дугаар сарын 17 –ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 22-нд “УБ хот дахь Гаалийн газар”-ийн удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“УБ хот дахь Гаалийн газар”- нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”-ыг ашиглаж байна. 2016 оноос Нягтлан бодох бүртгэлийн шинэ хууль хэрэгжиж байгаа. Тайлант онд

тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг бусад хуульд өөрчлөлт ороогүй байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой Гаалийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитын явцад төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг Гаалийн ерөнхий газар болон харъяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Гаалийн байгууллага нь үндэсний хөгжлийн зорилтод хувь нэмэр оруулах, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гадаад худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх эрхэм зорилготой.

Гаалийн байгууллагын гүйцэтгэх үндсэн үүрэг нь гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийж гаалийн болон бусад татвар, хураамжийг ногдуулах, хураах, албадан хураах, тэдгээрт хяналт тавих, гаалийн мэдээллийг системийг боловсронгуй болгох, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, хамгаалах, гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл гаргах, гаалийн хууль тогтоомжийг олон нийтэд таниулах, мэдээллээр хангах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хуульд заасан хариуцлага хүлээлгэх, гаалийн байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх, хуульд заасны дагуу оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал болно.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д заасны дагуу Улаанбаатар хот дахь Гаалийн газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд УСНББОУС, төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “УБ хот дахь Гаалийн газар”-ийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон

тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18 -г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “УБ хот дахь Гаалийн газар”-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан Гаалийн ерөнхий газрын даргын 2014 оны А/14 тоот тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

“УБ хот дахь Гаалийн газар”-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“УБ хот дахь Гаалийн газар”-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Ординат” ХХК болон “НьюРадинас” ХХК-ийн хамтарсан санхүүгийн “Unicus” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. “УБ хот дахь Гаалийн газар”-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

6. Материаллаг байдлын түвшин

Нийт зардлыг материаллаг байдлын суурь болгон сонгон авч, дээд түвшин буюу 2 хувиар тооцон 80,945.7 мянган төгрөгөөр материалын түвшинг тооцсон. /ТАБ-СТА-В-1/. Хяналтын үе шатанд материаллагын түвшинг дахин хянаад төлөвлөлтийн шатанд тооцсон түвшинг хэвээр үлдээсэн.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг

боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлыг төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

“УБ хот дахь Гаалийн газар”-ын төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс урсгал зардалд 3,614.7 сая төгрөг, ГЕГ-аас хөрөнгийн 64.0 сая төгрөгийн (хөрөнгө шилжин ирсэн) санхүүжилт тус тус авч, өмчийн хөрөнгө түрээслүүлсний 37.6 сая төгрөгийн орлого олсноос төрийн өмчийн хороонд орлогын 20 хувь болох 7.5 сая төгрөгийг шилжүүлсэн. Нийт санхүүжилтийн орлогоос урсгал зардалд 3,614.7 сая төгрөг батлагдсанаас 3,459.9 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 184.9 сая төгрөгийг Сангийн яамны Төв төрийн санд төвлөрүүлсэн байна. Тайлант онд Батлагдсан төсвийг 154.8 сая төгрөгөөр буюу 4.3 хувиар хэмнэсэн нь ажилчдын шилжилт хөдөлгөөн их гарсантай холбоотой байна.

8. Шилэн дансны мэдээлэл

“УБ хот дахь Гаалийн газар” нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу өөрийн байгууллагын <http://www.shilendans.gov.mn/org/695> цахим хуудсанд шилэн дансны мэдээллийг оруулсан байна.

9. Олж тогтоосон эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 27 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 18 горим, сорил гүйцэтгэв.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаа илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний үнийн дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой дараах алдаа дутагдлууд байсан. Үүнд:
 - Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэл бөглөөгүй.
 - Санхүүгийн тайлангуудыг 2 оноор зэрэгцүүлэн бэлтгээгүй /санхүүгийн байдлын тайлангаас бусад/.
 - Санхүүгийн тайлангийн тодруулгыг гүйцэт бэлтгээгүй байгаа нь Сангийн сайдыг 2006 оны 388-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын зөрчиж байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад нөхөн гаргуулж, засаж залруулсан.

2. Аккруэль суурийг тууштай баримтлахгүй байгаа нь Сангийн сайдыг 2006 оны 388-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.3 заалтыг өрчиж байна. Тухайлбал, 2015 оны 12-р сарын цахилгаан, дулааны төлбөрийг 2016 оны 1-р сард, 2016 оны 12-р сарын цахилгаан, дулааны төлбөрийг 2017 оны тайланд тусгаж байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

3. Зардлын ангиллыг тууштай мөрдөхгүй байна. Тухайлбал, Принтерийн хор худалдан авсан болон цэнэглүүлэхэд төлсөн төлбөрийг зардлын 3 данс (Багаж,техник хэрэгсэл, Ном, хэвлэл болон Бичиг хэрэг)-д хуваан бүртгэж байна. Энэ нь “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.7 заалтыг өрчиж байна

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайлангаа засварлаж өгсөн ба цаашид анхаарч ажиллах талаар Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

4. 2016 оны 1-р сард цахилгааны төлбөрт төлсөн 4,074.6 мянган төгрөгийг "Шуудан, холбоо, интернетийн төлбөр" гэсэн зардлын зүйлээр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад санхүүгийн тайлангаа засварлаж өгсөн.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

2016 оны 12-р сарын цахилгаан, дулааны төлбөрийн 4.6 сая төгрөгийн өглөгийг бүртгэлд тусгаагүй.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Дараагийн аудитаар авч үзэхээр асуудал байхгүй.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аудитын явцад нийт 12.6 сая төгрөгийн материаллаг бус адлаа болон зөрчил илэрсэний 8.0 сая төгрөгийн алдааг залруулсан.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 50 %-ийг хэрэгжүүлж, 50-ийг нь хэрэгжүүлээгүй буюу биднээс шалтгаалахгүй, ГЕГ-ын шийдвэрээс хамаарна гэсэн тайлбар өгсөн.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар хот дахь Гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрлөлт, төсвийн

гүйцэтгэлийн болон тайлбар, тодруулгад толилуулсан үлдэгдэл ажил гүйлгээнүүд холбогдох хууль, тогтоомж, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын тайланг хянасан:

САГ-ЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРАНЧИМЭГ ОГНОО:.....

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Я.САМБУУНЯМ ОГНОО:.....

Бэлтгэсэн:

ВОРЛДВАЙД ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн

АУДИТОР

З.СУМЪЯА ОГНОО:.....

Чанарын хяналт хийсэн:

ВОРЛДВАЙД ФАЙНЭНС АУДИТ ХХК-ийн

ЗАХИРАЛ:

Ч.БАЙГАЛЬ ОГНОО:.....



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УБ ХОТ ДАХЬ ГААЛИЙН ГАЗАР 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Улаанбаатар -15160, Бага тойруу -3,
Засгийн газрын IY байр

Менежментийн захидал

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараахь
хаягаар харилцана уу:

- Санхүүгийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
- Менежер Я.Самбууням
Утас: 260512
- Аудитор Н.Нямдаваа
Утас: 261885
- Ворлдвайд файнэнс аудит ХХК
Захирал: Ч.Байгаль
Утас: 99091342

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1.

Санхүүгийн тайлан бэлтгэсэн талаар (Хуудас 3)

Асуудал 2.

Зардлын ангилалын талаар (Хуудас 4)

2017 оны 02 дугаар сар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Улаанбаатар хот дахь Гаалийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан ГЕГ-ын харьяа "Улаанбаатар хот дахь Гаалийн ерөнхий газар"-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1. Санхүүгийн тайлан бэлтгэсэн талаар	Тэргүүлэх ач холбогдол № 1
--	-----------------------------------

Аудиторын ажиглалт

Аккрузель суурийг тууштай баримтлахгүй байгаа нь Сангийн сайдыг 2006 оны 388-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.3 заалтыг өрчиж байна. Тухайлбал, 2015 оны 12-р сарын цахилгаан, дулааны төлбөрийг 2016 оны 1-р сард, 2016 оны 12-р сарын цахилгаан, дулааны төлбөрийг 2017 оны тайланд тусгаж байна..

Аудиторын зөвлөмжүүд

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ Сангийн сайдыг 2006 оны 388 дугаар тушаалын 3-р хавсралтаар батлагдсан төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын дагуу аккрузель суурьт зарчмыг тууштай мөрдөн ажиллах.

Эрсдэл

- Тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн буруу илэрхийлэгднэ.
- Санхүүгийн байдлын тайланд өглөг, авлага дутуу илэрхийлэгдэнэ.

Үйлчлүүлэгчийн хариу

Төрийн сангаас авлага, өглөг үүсгэж болохгүй гэдэг.

Асуудал 1. Зардлын ангилалын талаар	Тэргүүлэх ач холбогдол № 2
--	-----------------------------------

Аудиторын ажиглалт

Зардлын ангиллыг тууштай мөрдөхгүй байна. Тухайлбал, Принтерийн хор худалдан авсан болон цэнэглүүлэхэд төлсөн төлбөрийг зардлын 3 данс (Багаж,техник хэрэгсэл, Ном, хэвлэл болон Бичиг хэрэг)-д хуваан бүртгэж байна. Энэ нь Сангийн сайдыг 2006 оны 388-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 2.1.7 заалтыг өрчиж байна.

Аудиторын зөвлөмжүүд

Тус журмын дагуу принтерийн хор худалдан авсан болон цэнэглүүлэхэд төлсөн төлбөрийг зардлыг "Бичиг хэргийн зардал"-д бүртгэж байх, цаашид энэ ангиллаа тогтвортой мөрдөх, хэрэв төсөв хэтэрсэн бол Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29 ны өдрийн 73 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ыг мөрдөн ажиллах, Шашид төсвийн зардлын ангиллыг зөв хийж хэвших.

Эрсдэл

- Төсвийн гүйцэтгэлийн тайлан алдаатай бэлтгэгдэх,
- Холбогдох хууль, дүрэм, журам, тогтоол зөрчигдөх

Үйлчлүүлэгчийн хариу.

Санхүүгийн тайлангаа засварлаж өгсөн. Цаашид анхаарч ажиллана.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/

Балансын зүйл	Үлдэгдэл	
	2015 он	2016 он
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
АВЛАГА	19,418,499.00	15,062.23
Бусад авлага	19,418,499.00	15,062.23
Байгууллагаас авах авлага	19,418,499.00	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	15,062.23
БАРАА МАТЕРИАЛ	47,218,003.55	52,443,611.55
Бэлэн бүтээгдэхүүн	17,736,873.75	22,671,265.75
Хангамжийн материал	28,081,129.80	28,372,345.80
Мал амьтад	1,400,000.00	1,400,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	66,636,502.55	52,458,673.78
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,668,669,004.62	4,207,272,289.24
<i>Биет хөрөнгө</i>	<i>4,667,009,629.62</i>	<i>4,206,287,914.24</i>
Барилга,байгууламж,орон сууц	4,571,362,295.48	4,211,980,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(477,198,607.95)	(350,998,333.20)
Авто-тээврийн хэрэгсэл	193,382,690.50	173,344,690.50
Хуримтлагдсан элэгдэл	(108,361,857.23)	(107,573,857.27)
Машин,тоног төхөөрөмж (компьютер)	1,142,805,025.55	550,578,767.64
Хуримтлагдсан элэгдэл	(821,855,763.47)	(423,441,329.97)
Тавилга, аж ахуйн эд хогшил	345,942,677.59	343,173,677.59
Хуримтлагдсан элэгдэл	(179,066,830.85)	(207,442,367.65)
Бусад үндсэн хөрөнгө	-	20,000,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-	(3,333,333.40)
<i>Биет бус хөрөнгө</i>	<i>1,659,375.00</i>	<i>984,375.00</i>
Програм хангамж	3,200,000.00	3,200,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,540,625.00)	(2,215,625.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,668,669,004.62	4,207,272,289.24
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,735,305,507.17	4,259,730,963.02
ӨР ТӨЛБӨР		-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Бусад өглөг	51,000.00	-
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	51,000.00	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧ		
Засгийн газрын оруулсан капитал	6,753,678,238.38	6,753,678,238.38
Хуримтлагдсан үр дүн:	(2,032,641,054.06)	(2,508,164,598.21)
- Өмнөх үеийн үр дүн	(2,032,641,054.06)	(2,032,641,054.06)
- Тайлант үеийн үр дүн	-	(475,523,544.15)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,217,322.85	14,217,322.85
ЦЭВЭР ХӨРӨНГӨ,ӨМЧИЙН ДҮН	4,735,254,507.17	4,259,730,963.02
НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,735,305,507.17	4,259,730,963.02

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,077,537,496.49	3,679,658,199.92
Улсын төсвөөс - Урсгал	3,815,272,620.00	3,615,672,700.00
Хөрөнгийн	258,664,876.49	63,985,499.92
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	3,600,000.00	
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	30,257,800.00	37,638,250.00
Түрээсийн орлого	30,257,800.00	37,638,250.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,107,795,296.49	3,717,296,449.92
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	3,690,035,363.47	3,361,688,990.21
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,332,425,814.53	3,027,465,697.86
Цалин	3,170,505,594.53	2,908,080,097.86
Унаа хоолны хөнгөлөлт	119,448,000.00	119,385,600.00
Урамшуулал	42,472,220.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	357,609,548.94	334,223,292.35
БАРАА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	489,816,060.98	492,515,444.01
Тогтмол зардал	43,857,720.16	49,312,448.00
Гэрэл, цахилгаан	27,873,110.00	32,481,470.00
Түлш, халаалт	13,181,255.00	14,212,475.00
Цэвэр, бохир ус	2,803,355.16	2,618,503.00
Бусад бараа үйлчилгээний зардал	20,952,539.41	29,863,094.32
Бичиг хэрэг	4,460,270.00	11,306,230.00
Тээвэр, шатахуун	7,823,000.00	7,128,300.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	5,373,650.41	4,014,539.32
Ном, хэвлэл	-	3,758,198.78
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	845,078.00	1,330,450.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,450,541.00	2,325,376.22
Эд хогшил, урсгал засварын зардал	7,274,044.00	7,335,146.00
Багаж, техник, хэрэгсэл	1,120,900.00	2,015,446.00
Урсгал засвар	6,153,144.00	5,319,700.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	73,802,519.00	70,608,053.12
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	20,803,200.00	26,405,568.12
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	3,037,425.00	2,258,010.00
Тээврийн хэрэгслийн татвар	327,400.00	309,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,994,122.00	138,417.00
Газрын төлбөр	-	261,700.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	46,640,372.00	39,234,858.00
Бараа үйлчилгээний бусад зардал	343,929,238.41	335,396,702.57
Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,000,397.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	90,000.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	343,929,238.41	333,306,305.57
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,152,513.96	193,423,050.12
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	1,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	36,152,513.96	192,423,050.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,216,003,938.41	4,047,627,484.34
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(108,208,641.92)	(330,331,034.42)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	145,192,509.73
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	145,192,509.73
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(108,208,641.92)	(475,523,544.15)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,818,923,620.00	3,615,672,700.00
Улсын төсвөөс - Урсгал	3,406,792,620.00	3,615,672,700.00
Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	30,308,800.00	
Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	381,822,200.00	-
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	37,772,530.00	37,638,250.00
Түрээсийн орлого	37,772,530.00	37,638,250.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,856,696,150.00	3,653,310,950.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	3,670,530,642.47	3,342,336,553.44
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,311,616,842.47	3,045,866,929.96
Нийгмийн хамгааллын шимтгэл	358,913,800.00	296,469,623.48
БАРАА. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	103,887,743.57	117,551,346.44
Тогтмол зардал	44,466,053.16	49,312,448.00
Гэрэл, цахилгаан	28,481,443.00	32,481,470.00
Түлш, халаалт	13,181,255.00	14,212,475.00
Цэвэр, бохир ус	2,803,355.16	2,618,503.00
Бусад бараа үйлчилгээний зардал	18,800,761.41	16,816,228.32
Бичиг хэрэг	3,363,660.00	3,270,650.00
Тээвэр, шатахуун	7,151,700.00	5,849,000.00
Шуудан, холбоо, интернетийн төлбөр	4,765,317.41	4,014,539.32
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	805,000.00	1,168,750.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,715,084.00	2,513,289.00
Эд хогшил, урсгал засварын зардал	7,280,144.00	10,995,265.00
Багаж, техник, хэрэгсэл	1,127,000.00	2,753,215.00
Урсгал засвар	6,153,144.00	8,242,050.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,689,785.00	40,122,905.12
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,480,402.00	26,448,800.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	3,037,425.00	2,258,010.00
Тээврийн хэрэгслийн татвар	327,400.00	309,500.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,365,185.12
Газрын төлбөр	261,700.00	261,700.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,582,858.00	7,479,710.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,651,000.00	304,500.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,651,000.00	304,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	82,277,763.96	193,423,050.12
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	38,610,520.00	1,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	43,667,243.96	192,423,050.12
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	3,856,696,150.00	3,653,310,950.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	-	-
МӨНГӨ,ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-	-

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАИЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/				
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(1,924,432,412.14)	4,843,463,149.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(1,924,432,412.14)	4,843,463,149.09
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(108,208,641.92)	(108,208,641.92)
2015 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(2,032,641,054.06)	4,735,254,507.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(2,032,641,054.06)	4,735,254,507.17
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлангийн үеийн үр дүн	-	-	(475,523,544.15)	(475,523,544.15)
2016 оын 12 сарын 31-р үлдэгдэл	6,753,678,238.38	14,217,322.85	(2,508,164,598.21)	4,259,730,963.02

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	3,614,672,700.00	3,653,310,950.00	(38,638,250.00)	101.1
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	3,614,672,700.00	3,459,887,899.88	154,784,800.12	95.7
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	3,491,458,200.00	3,342,336,553.44	149,121,646.56	95.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,090,116,500.00	2,992,724,129.96	97,392,370.04	96.8
Гэрээт ажлын хөлс	57,974,000.00	53,142,800.00	4,831,200.00	91.7
Нийгмийн хамгааллын шимтгэл	343,367,700.00	296,469,623.48	46,898,076.52	86.3
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	123,214,500.00	117,551,346.44	5,663,153.56	95.4
Тогтмол зардал	52,515,000.00	49,312,448.00	3,202,552.00	93.9
Гэрэл, цахилгаан	25,325,000.00	32,481,470.00	(7,156,470.00)	128.3
Түлш, халаалт	23,690,000.00	14,212,475.00	9,477,525.00	60.0
Цэвэр, бохир ус	3,500,000.00	2,618,503.00	881,497.00	74.8
Хангамж, бараа материалын зардал	16,817,000.00	16,816,228.32	771.68	100.0
Бичиг хэрэг	4,134,400.00	3,270,650.00	863,750.00	79.1
Тээвэр, шатахуун	6,098,100.00	5,849,000.00	249,100.00	95.9
Шуудан,холбоо, интернетийн төлбөр	3,411,600.00	4,014,539.32	(602,939.32)	117.7
Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	1,995,300.00	1,168,750.00	826,550.00	58.6
БҮТЭЗҮЙЛС	1,177,600.00	2,513,289.00	(1,335,689.00)	213.4
Эд хогшил, урсгал засварын зардал	10,883,200.00	10,995,265.00	(112,065.00)	101.0
Багаж,техник хэрэгсэл	1,347,700.00	2,753,215.00	(1,405,515.00)	204.3
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,425,500.00	-	2,425,500.00	-
Урсгал засвар	7,110,000.00	8,242,050.00	(1,132,050.00)	115.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,738,300.00	40,122,905.12	2,615,394.88	93.9
Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,987,700.00	26,448,800.00	538,900.00	98.0
Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	4,000,000.00	2,258,010.00	1,741,990.00	56.5
Тээврийн хэрэгслийн татвар	408,900.00	309,500.00	99,400.00	75.7
Мэдээлэл,технологийн үйлчилгээ	1,600,000.00	1,365,185.12	234,814.88	85.3
Газрын төлбөр	261,700.00	261,700.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	7,480,000.00	7,479,710.00	290.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	261,000.00	304,500.00	(43,500.00)	116.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	261,000.00	304,500.00	(43,500.00)	116.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	193,423,050.12	(193,423,050.12)	-
Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,урамшуулал	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
Улсын төсвөөс олгосон санхүүжилт,шилжүүлэг	-	184,895,400.12	(184,895,400.12)	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	184,895,400.12	(184,895,400.12)	-
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт,шилжүүлэг	-	7,527,650.00	(7,527,650.00)	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,527,650.00	(7,527,650.00)	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,653,310,950.00	(3,653,310,950.00)	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	37,638,250.00	(37,638,250.00)	-
Төрийн өмч түрээслүүсний орлого	-	37,638,250.00	(37,638,250.00)	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	3,615,672,700.00	(3,615,672,700.00)	-
Улсын төсвөөс санхүүжих	-	3,615,672,700.00	(3,615,672,700.00)	-
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	(3,614,672,700.00)	-	(3,614,672,700.00)	-
АЖИЛЛАГСАД БҮГД	190	228	(38.00)	120.0
Удирдах ажилтан	3	3	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	164	198	(34.00)	120.7
Үйлчлэх ажилтан	21	25	(4.00)	119.0
Гэрээт ажилтан	2	2	-	100.0